

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2023 оны 09 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан

2023 оны 09 дугаар сарын 27-ны өдөр

Ерөнхий боловсролын сургууль :

- 1 дүгээр ангид элсэгчдийн бүртгэлийг цахимаар бүртгэж нийт 43 суралцагч элсэн орсон.

Нийт 52 багш, ажилтантай, 441 суралцагчтай.

- 2003 оны 35-р төгсөлтийн 8а ангийн төгсөгчид төр өлх сургуулийнхаа , суралцаж байсан ангидаа 4685000 төгрөгийн өртөг бүхий багш, сурагчийн ширээ сандал хандивлалаа.
- БШУГ-аас зохион байгуулсан “Дотуур байрын хүүхдийн аюулгүй байдал, хөгжил, хамгаалал” сэдэвт дотуур сургалтад дотуур байрын багш хамрагдав.
- Сул орон тооны ажлын байрны зарлагдаж Хоол зүйч -1, Түүх газар зүйн багш -1, Технологийн багш -1 шинээр ажилд орсон.
- Хичээлийн “Б” байрны их засвар 09 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн хийгдэж эхэлсэн.
- Монгол Японы хамтарсан эмнэлэг болон АНЭ-т нийт албан хаагчид \49\ эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцийн үзлэгт бүрэн хамрагдсан.
- 2023 оныг " Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жил " болгон зарласантай холбоотой Аймгийн засаг даргын 2023 оны 08-р сарын 01-ний өдрийн А/478 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд шүдний өвчлөлийг илрүүлэх, бууруулах, эрүүлжүүлэх арга хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөс 100 сая төгрөгийг аймгийн хэмжээнд батласан байна. 9-р сарын 18,19,20-ний өдрүүдэд АНЭ-ийн нүүр ам судлалын ахлах зэрэгтэй эмч С.Тунгалаг ажиллалаа. Нийт 429 суралцагч үзлэгт хамруулан 104 хүүхдийг эмчилж , 39 хүүхдийг бүрэн эрүүлжүүлсэн байна. Хамгийн олон эрүүл шүдтэй анги - бага ангиас Г.Тунгалаг багштай 4а анги, дунд ангиас Ц.Алтантүлхүүр багштай 8б анги байлаа.
- Намрын спартакиадыг 1-3 дугаар ангийн суралцагчдын дунд 4 төрлөөр, 4-6 дугаар ангийн суралцагчдын дунд 5 төрлөөр, 7-9 дүгээр ангийн суралцагчдын дунд 6 төрлөөр зохион байгуулж нийт 439 суралцагч авхаалж самбаагаа сорьж өрсөлдлөө.
- Боловсролын Ерөнхий газрын арга зүйч Г.Энхтулга “ЕБС-ийн суралцагчийн хичээл сургалтыг үнэлэх шалгуур, хэрэглэх арга зүй” сэдэвт сургалтыг ажлын байранд дээр зохион байгуулж явууллаа. Нийт 25 багш хамрагдлаа. 2023.09.21
- Сургуулийн дотуур байранд нийт 70 хүүхэд амьдарч байна.
- Сумын ИТХ-ын Нутгийн удирдлага, Нийгэм, Цахим бодлогын хөгжлийн хорооноос дотуур байр болон үдийн хоолны чанар хүртээмжид хяналт шалгалт хийлээ.

Хүүхдийн цэцэрлэг:

- ✓ 2023-2024 оны хичээлийн жилд 5 бүлэгт 160 хүүхдийг хамруулан сургалт үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.
- ✓ Хичээлийн жилийн эхэд аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран цагаан хорхойн шинжилгээнд 148 хүүхдийг хамрууллаа.

- ✓ Багш нарыг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан ба дараагийн шатанд үзүүлэх шаардлагатай 4 багш, ажилтаныг үзлэг шинжилгээнд хамруулж байна.
- ✓ Хувилбарт сургалтад энэ хичээлийн жилд 73 хүүхдиг хамруулсан ба “Гэр бүлийн орчинд сургууль бэлтгэх хөтөлбөр”-ин хүрээнд 19 хүүхдийг хамруулж байна
- ✓ Дээрх хөтөлбөрийн хүрээнд Аймгийн 8-р цэцэрлэг манай цэцэрлэгийн хувилбарт сургалтын талаар туршлага судлаж, хамтран ажиллахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- ✓ Өмнөх хичээлийн жилд Бэлтгэл бүлэг төгсгөсөн 2 багш “Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ”-г ЕБС-тэй амжилттай зохион байгууллаа.
- ✓ Ажлын байран дээр 2 төрлийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 32 багш ажилтан хамрагдлаа.

Соёлын төв:

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Засгийн газрын 2010 оны долоодугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4.1.27 дугаар заалтын дагуу жил бүрийн есдүгээр сарын хоёр дахь ням гарагт Соёл, урлагийн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг болсон.

Үүний хүрээнд : ЕБС-ийн VI-IX дүгээр ангийн сурагчдын дунд “Соёлын орон зай” сэдэвт чөлөөт ярилцлага хийж идэвхтэй оролцсон хүүхдүүдийг урамшуулж гарын бэлэг өгч урамшуулсан. Нийт 82 сурагчид хамрагдаж оюундаа хөрөнгө оруулалт хийлээ.

ХОЁР: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2.1 2023 оны “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН”-аас 57-н сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “ОРОН НУТАГ СУДЛАХ ТАНХИМ”-ын тохижилтын ажил хийгдсэн.

3.2 НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

“ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР”- ийг тохиолдуулан хүүхэд багачуудад ном уншихын ач холбогдолын талаар таниулах, уншсан номын тэмдэглэл хөтлөх, эх хэлний баялаг, уран үгсийн сангаар аялж цаашид сурах их үйлсдээ ашиглах, эх хэлээрээ бахархах сэдэл төрүүлэх зорилгоор ХҮҮХДИЙН НОМ, УРАН ЗОХИОЛЫН НОМ гэсэн ангилалуудаар номын үзэсгэлэнг зохион байгууллаа.

Тус үзэсгэлэнгийн үед уншигчдад үнэ төлбөргүй уншигчын карт нээх үйлчилгээ үзүүлж нийт 11 карт шинээр нээж, давхардсан тоогоор 70 гаруй хүн үзэсгэлэнг үзэж сонирхлоо.

3.3 “АХА” ТЭМЦЭЭН

Сурагчдын танин мэдэхүйг хөгжүүлэх, чөлөөт цагийг идэвхтэй өнгөрөөх, оюуны алжааг тайлах зорилгоор танин мэдэхүйн, хөгжөөнт асуулт хариултын тэмцээнийг IV-XI ангийн сурагчдын дунд 2 үе шаттайгаар зохион явуулж. Тэмцээнд 8а ангийн сурагч Б.Есүй тэргүүн байр эзэлж дурсамж гарын бэлэг гардуулав.

3.4 “ШҮЛГИЙН ЧЕЛЛЭНЖ”

Ард иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх яруу найраг шимтэн сонирхох, уран унших, эх орон, ёс заншил, түүх соёл, оюуны үнэт зүйлсээ эрхэмлэн дээдлэх түүгээрээ бахархах үндэсний ухамсрын төлөвшлийг дэмжих зорилгоор цахим шүлгийн чөллөнж эхлүүлэн 9 дүгээр сарыг дуустал үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөж байна.

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1 Түүх, соёл дурсгалын талаарх ховор сонирхолтой зүйлсийг цуглуулан хамгаалах, нийтэд үзүүлэх, үзэсгэлэн гаргах зорилготой Орон нутгийн хөгжлийн сан-аас 57-н сая төгрөгийн төндэр зарлагдаж, “Хүрэл Соёмбо” ХХК шалгарч, 2023оны 08сард “ОРОН НУТАГ СУДЛАХ ТАНХИМ”-ын тохижилтын ажил хийгдэж дууссан.

ТАВ: СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:

6.1 “СОЁЛ-СПОРТ” арга хэмжээнд: Холимог волейбол, дартс, хөгжөөнт буухиа, ширээний теннис гэсэн төрлүүдээр явагдсан. Буухиа- алт медаль, ширээний теннис-мөнгөн медаль, Холимог волейбол- 4р байранд шалгарч амжилттай оролцлоо.

6.2 “Эрдэм билиг оюунт дэлхийн иргэн”-ийг бэлтгэхээр тэмүүлэн хичээж буй: Эрхмийн дээд багш нартаа, Энхрий үрсээ урамшуулан дэмждэг эцэг, эх асран хамгаалагчдадаа- зориулсан хөтөлбөрт арга хэмжээ зохион байгуулсан.

6.3 Соёлы орон зайг бий болгон Соёл урлагийн ажилтны өдрийг мэргэжил, үйл ажиллагааг сурталчлах өдөр болгон зарласантай холбогдуулан албан байгууллага, аж ахуй нэгж, ард иргэдийн дунд Буухиа, ТаТа тунгаа тэмцээнийг 2023 оны 09 сарын 10-нд зохион байгууллаа. Тус тэмцээнд 4 багийн 20-н хүн оролцсон байна.

6.4 Соёл урлагийн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 09 сарын 10-ны өдөр “Хөтөлбөртэй үдэшлэг” зохион байгуулсан. Нийт 53 хүн үзэж сонирхсон.

ДОЛОО: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1 Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслаж, хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, ажлын үр дүнг нэмэгдүүлэх, зөвлөмж аргазүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор: **2023** оны 09 сарын 10-ны өдөр Соёл урлагийн газраас 5-н хүний бүрэлдэхүүнтэй 26-н чиг үүргийн дагуу зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

7.2 УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГСЭД-ийн дурсгалыг хүндэтгэх, эргэн дурсах 28 дахь өдрийг тохиолдуулан ЕБС-ийн 7-9-р ангийн 120 гаруй сурагчдад "Монголд гарсан улс төрийн хэлмэгдүүлэлт" сэдвээр дүгнэлт, сургамж хичээлийг ЕБС-ийн Түүх, нийгмийн багш Ц.Алтантүлхүүр орж хэлмэгдүүлэлтийн хор уршгийг залуу үеийнхэнд сурталчилан таниулалаа.

7.3 Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ж.Батсуурь, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Д.Шижирбаатар нар Баян, Дэлгэр, Жавхлант багийн иргэд хөдөлмөрчидтэй уулзаж, төр засгийн бодлого шийдвэр болон гишүүдийн зүгээс орон нутагт хийгдэх ажлыг танилцуулж, иргэдийн асуултанд хариу өгөв.

7.4 Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагддаг “Спорт-2023” ахмадын олон төрөлт баруун бүсийн шугаман бүжгийн тэмцээнд 50-59 нас, 60-с дээш насны ангилалд бүжгийн багш А.Мөнгөнсүлд бэлтгэж тус тус I-р байр эзэлсэн.

НАЙМ: Сургалтууд

8.1 09 сарын 14-нд Соёлын яамнаас хэрэгжүүлж буй КИНО ТӨСӨЛ-тэй холбоотойгоор “Т” энтертайнментын сургалтанд цахимаар оролцсон.

8.2 “Бүх нийтийн соёлын боловсрол” анхан шатны сургалтанд Номын санч Б.Эрдэнэбулган, БМС-ч Б.Цэвэл нар хамрагдаж батламж гардан авсан.

НИЙГМИЙН ДААТГАЛ:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 545839.4 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -484056.2 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 45583.4 мян төг
- ЭМДаатгалын шимтгэл -16199.8 мян төг орлоо.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох-13 тэтгэврээ өөрчлөн тогтоолгох- өргөдөл-2 , Банк солих-13, тэтгэмж-33, ажилгүйдлын тэтгэмж-2 , илүү төлсөн шимтгэл буцаах-13 малчнаар ажилласан жилээ тогтоолгох -0 нийт 76 өргөдлийг хүлээн авч бүрэн шийдвэрлэж, 334 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож, олгох ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж НДаатгалын санд мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлж, тэтгэврийн санд 1533153,7 мян төгрөгний санхүүжилт, тэтгэмж дээр 0,0 мян төгрөгний санхүүжилт авснаар

- Тэтгэвэрт - 479 тэтгэвэр авагчдад 1695779,4 мян төгрөгний тэтгэвэр,
- ХЧТА тэтгэмжинд- 9 даатгуулагчдад 616,8 мянган төгрөг,
- Оршуулгын тэтгэмжинд- 8 тэтгэвэр авагчдад 16000,0 мян төгрөг,
- Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг- 16 даатгуулагчдад 22915,3 мян төг,

нийт 1735311,5 мян төгрөгний тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгоод олголтын зөрчилгүй ажиллаж байна.

Нийгмийн даатгалд хамраг-даагүй “Рашааны тунгаамал” ХХК-ийг шинээр нийгмийн даатгалд хамруулан 107,8 мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлэн авлаа.

Иргэдийн мэдээллийн цагаар Нийгмийн даатгалын хуулинд орсон өөрчлөлтөөр сургалт хийлээ.

Сумын нийгмийн даатгалын сангийн тайланг цахимаар гаргаж нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв.

2022 оны харилцахын-4, тооцооны хуудас тайлан-2, хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан-1 зогсоогдсон 27 тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.